

Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Түрээслэх оффисын байр нь дараах шалгуурыг хангасан байвал зохино

№	Оффисын байр	Тавигдах шаардлага
1	Байршил	Хотын А бүсэд байрлах
2	Зориулалт	Оффисын зориулалтаар ашигладаг, үйл ажиллагаа нь жигдэрсэн, тохилог байх
3	Зогсоол	Албан хаагчид болон үйлчлүүлэгдэд зориулсан авто зогсоолын 4-өөс доошгүй талбайтай байх. (Өвлийн дулаан гараштай байх)
4	Талбайн хэмжээ	80 м ² -с доошгүй байх
5	Бусад	Түрээсийн байрны цэвэрлэгээ, 24 цагийн харуул хамгаалалттай байх. Оффисын барилга нь дулаан, цахилгаан, усан хангамжийн болон бусад дэд бүтцийн систем жигдэрсэн байх. Оффисын өрөө, тасалгааны дулаан, агаар сэлгэлтийг холбогдох стандартын дагуу шийдвэрлэж хэрэгцээт тоног төхөөрөмжөөр тоноглосон байх. Ойр орчимдоо үйлчилгээний газартай байх. Телефон утасны болон интернетийн холболттой, эсвэл холболт хийх боломжтой байх.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тавигдах шаардлага:

1. Түрээсийн байрны тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээнд осол гэмтэл, эвдрэл гарвал цаг тухайд нь засварлах хүний нөөц, техникийн, санхүүгийн болон бусад хүчин чадалтай байх.
2. Тухайн барилгын инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бүрэн бүтэн байдал болон гадна орчны ариун цэвэр, тохижилтод байнгын хяналт тавих хүчин чадалтай байх.
3. Түрээсийн байрны шугам сүлжээ, инженерийн тоног төхөөрөмжид норматив хугацаа болсон тохиолдолд их засвар хийх, урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийж, түүний засвар үйлчилгээг хийж байх.